БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, БАЙНГЫН
АЖИЛЛАГААТАЙ ДЭД ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА С.АМАРСАЙХАН

2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Арга хэмжээний чиглэл, нэр | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|
| | **Нэг. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох** | | |
| 1.1 | Барилга байгууламжийг буулгах, шинээр барилгажуулах, хүчитгэх ажлыг зохион байгуулахтай холбоотой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх санал боловсруулж хэрэгжүүлэх | Жилд | ХББОСЯ |
| 1.2 | Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах ажлыг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах арга хэмжээг авч ажиллах | Жилд | ХББОСЯ |
| 1.3 | Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд барилгын дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, паспортжуулалтын зөвлөлийг шинэчлэн байгуулж ажиллуулах | I, II улирал | Аймгийн ЗД |
| 1.4 | Барилгын үндсэн хийц бүтээцийн бэхэлгээ хүчитгэлийн техникийн шийдлийг боловсруулах, батлах (Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл-2) | Жилд | ХББОСЯ, ОБЕГ, |
| | **Хоёр. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах** | | |
| 2.1 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, тайлагнах | II, IV улиралд | Яамдууд, Аймаг, нийслэлийн ЗД, |
| 2.2 | Булган, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг хийх, инженер-геологи, гидрогеологийн судалгааны ажлын үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх | II, III улирал | СЯ, ХББОСЯ, ГЗБГЗЗЕГ, ООГХ |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3 | Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах ангийн барилга байгууламжид газар хөдлөлтөд тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулах | III, IV улирал | Аймаг, нийслэлийн ЗД |
| 2.4 | Гамшгийн аюулын зарлан мэдээллийн системийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай техник, хэрэгслийн судалгаа, тооцоог боловсруулан танилцуулж шийдвэрлүүлэх хүн амд шуурхай хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх | Жилд | Аймгийн ЗД, ОБЕГ |
| 2.5 | Газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хурдатгал хэмжигч багажийг аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт суурилуулах, шаардлагатай хөрөнгийг гаргах | Жилд | СЯ, Аймаг, нийслэлийн ЗД, ООГХ |
| 2.6 | Нийслэлийн Гамшгаас хамгаалах албадад бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | II-III улирал | НЗД |
| 2.7 | Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын бичил мужлалын мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системд оруулах | Жилд | ГЗБГЗЗЕГ |
| 2.8 | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын газар хөдлөлт бүртгэх байнгын ажиллагаатай 48 станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Жилд | ГЗБГЗЗЕГ |
| 2.9 | "Сэлэнгэ", "Мандалговь" газар хөдлөлтийн идэвхжилтийг хянах станцад шаардлагатай зардлыг шийдвэрлэх | III улирал | СЯ, ЭЗХЯ |
| 2.10 | Газар хөдлөлт бүртгэх станц болон аюулыг анхааруулах системийн станцуудын сэлбэг хэрэгслийн зардлыг шийдвэрлэх | III улирал | СЯ, ЭЗХЯ |
| 2.11 | Улсын хэмжээнд ашиглагдаж буй 2002 оноос өмнө ашиглалтад орсон болон ашиглалтын шаардлага хангахгүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байрны барилга, байгууламжийг паспортжуулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх | Жилд | ХББОСЯ, БЯ, ЭМЯ, Аймаг, нийслэлийн ЗД |
| 2.12 | Монгол улсын босоо тэнхлэгийн дагуух бүс нутгийн геологийн болон геоэкологийн чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудыг нэгтгэх, газар хөдлөлтийн үед эрсдэлийн үнэлгээ хийх үед ашиглагдах геологи, тектоник, геоэкологи, гидрогеологийн суурь судалгааны материалын үр дүнг нэгтгэн мэдээлэл бүрдүүлэх | III, IV улирал | ШУА |
| **Гурав. Бэлэн байдлыг дээшлүүлэх** | | | |
| 3.1 | Болзошгүй гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх, түр цуглах талбай, түр байрыг томилгоожуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангуулах | Жилд | Аймаг нийслэлийн ЗД, ОБЕГ |
| 3.2 | Эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, эрсдэлийн сан бүрдүүлэх, сайн дурын донорын тоог нэмэгдүүлэх | Жилд | ЭМЯ, МУЗН |
| 3.3 | Газар хөдлөлтийн гамшгийн үед хэрэглэх хүнс, бараа материалын нөөцийг бүрдүүлэх, сэлгэх | Жилд | ХХААХҮЯ, Аймаг, нийслэлийн ЗД, ОБЕГ |
| 3.4 | Хүнсний нөөцийн агуулах, элеваторын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, хүнсний ногооны агуулах, зоорийг нэмэгдүүлэх | Жилд | ХХААХҮЯ, Аймгийн ЗД |

| | | | |
|---|---|---|---|
| 3.5 | Шарил хадгалах зориулалтын хөргөгчний тоог нэмэгдүүлэх, судалгаа гаргах | Жилд | ЭМЯ |
| 3.6 | Гамшгийн үед анхан шатны нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сайн дурын идэвхтэн, улаан загалмайн ажилтнуудыг бэлтгэх, мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулах | Жилд | ЭМЯ, МУЗН |
| 3.7 | Сүхбаатар аймгийн Дарьганга сумын (SUA2) станцын эх хавтанг солих, Хэнтий аймгийн Батширээт сумын (HEA2) станцын эрчим хүч, өгөгдөл дамжуулалтыг шинэчлэх | Жилд | ГЗБГЗЗЕГ |
| **Дөрөв. Гамшгаас хамгаалах сургалт, дадлага** | | | |
| 4.1 | "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр", гамшгийн аюулыг зарлан мэдээллэх дохиогоор ажиллах дадлага, сургуулийг улсын хэмжээнд зохион байгуулах | I улирал | Аймаг, нийслэлийн ЗД, ОБЕГ |
| 4.2 | Иргэдэд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах сургалт, дадлага хийх, гарын авлага, сургалтын материалыг боловсруулж нийтийн хүртээл болгох телевиз, радиогоор хичээл заах, шторк, баримтат кино гаргах зэрэг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | Жилд | БЯ, ОБЕГ, Аймаг, нийслэлийн ЗД, МУЗН |
| 4.3 | Бүх шатны боловсролын байгууллагад газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | Жилд | БЯ |
| 4.4 | Зам, тээвэр улсын алба, Уул уурхайн улсын албанд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах, Түлш, эрчим хүчний улсын албанд гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах | Жилд | ЗТЯ, АҮЭБЯ, ЭХЯ, ОБЕГ |
| 4.5 | Сүхбаатар, Төв аймагт гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах, Булган аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах | Жилд | Аймгийн ЗД, ОБЕГ |

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх Байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн 2025 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 4 зүйл 28 заалттай.

Тайлбар:

- БАДЗ — Байнгын ажиллагаатай дэд зөвлөл
- АҮЭБЯ — Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
- БЯ — Боловсрол яам
- СЯ — Сангийн яам
- ССАЖЗЯ — Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

- ХХААХҮЯ — Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- ХБЕОСЯ — Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам
- ЦХИХХЯ — Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
- ЗТЯ — Зам, тээврийн яам
- ЭМЯ — Эрүүл мэндийн яам
- ЭХЯ — Эрчим хүчний яам
- ЭЗХЯ — Эдийн засаг хөгжлийн яам
- ОБЕГ — Онцгой байдлын ерөнхий газар
- ГЗБГЗЗЕГ — Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
- ООГХ — Одон орон, геофизикийн хүрээлэн
- ҮГА — Үндэсний геологийн алба
- НЗД — Нийслэлийн Засаг дарга
- АЗД — Аймгийн засаг дарга

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ДЭД ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА